



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/23

Улаанбаатар хот

“Сити тур” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх тухай”

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны “Сити тур” төслийг хэрэгжүүлэх тухай 47 дугаар тогтоол, 2020 оны 02/09, 02/10 дугаар тогтоол 2021 оны 11/34 дүгээр тогтоол, газрын дүрмийн 4.1.10-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2022 оны 01-р сарын 03-ны өдрийн 2022 оныг “Хотын иргэний жил болгон зарлах тухай” А/01 дүгээр захирамжийн хүрээнд “Сити тур” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж ажилласугай.

2. “Сити тур” төсөл хэрэгжүүлэх шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. “Хотын аялал”-ыг зохион байгуулахад шаардагдах үйл ажиллагааны зардал 80 347 000 /наян сая гурван зуун дөчин долоон мянга / төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Өнөржаргал/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг танилцуулахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс /В.Батчимэг/-т даалгасугай.

ДАРГА  Д.БАТСҮХ



1150500181

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2022 оны 04 дүгээр
сарын 29 -ны өдрийн 403 дугаар
тушаалын хавсралт

“СИТИ ТУР” ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСВИЙН ЗАДАРГАА

2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

№	Зарцуулалт	Тоо ширхэг	Нэгж дүн (төгрөг)	Нийт дүн (төгрөг)
1	Аяллын менежерийн цалин	1 хүн*6 сар	1,200,000	7,200,000
2	Аяллын хөтчийн цалин	2 хүн*6 сар	1,200,000	14,400,000
3	Автобусны жолоочийн цалин	2 хүн*6 сар	1,200,000	14,400,000
4	Ажилчдын хувцасны зардал	5	200,000	1,000,000
5	Маркетинг сурталчилгааны зардал	1	2,000,000	2,000,000
6	Хэвлэх материалын зардал /тасалбар, танилцуулга/	3,500ш	1,500	5,250,000
7	Шатахууны зардал	2*2071л	3,380₮	14,000,000
8	Тос масло, сэлбэг хэрэгсэл, засвар, угаалга цэвэрлэгээ	2	2,000,000	4,000,000
9	Будах зардал	2	5,700,000	11,400,000
10	Техникийн хяналтын үзлэг, оношлогоо	2	30,000	60,000
11	Тээврийн хэрэгслийн татвар	2	132,000	264,000
12	Жолоочийн хариуцлагын даатгал	2	186,500	373,000
13	Гражийн төлбөр /10 сараас/	2	3,000,000	6,000,000
НИЙТ				80,347,000

--o0o--